



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот


“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
журам батламжлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 373 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг батламжлах, бүртгэх тухай заавар”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор баталсан “Арилжааны журам”-ын нэмэлт өөрчлөлт, 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/09, 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дүгээр тогтоолуудаар шинэчлэн баталсан “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам”, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг тус тус батламжилсугай.

2. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын эрх ашгийг хамгаалах, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН